



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/122

Ховд

“Оюутан цэрэг” сургалтыг зохион байгуулж  
явуулах тухай

Монгол Улсын “Цэргийн албаны тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 32 дугаар тогтоол, Батлан хамгаалах сайдын 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/376 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Оюутан цэрэг” сургалтыг 2019 оны 04 дүгээр сарын 01-нээс 08 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлхи хугацаанд зохион байгуулж явуулсугай.

2. “Оюутан цэрэг” сургалтыг удирдан зохион байгуулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчаар:

Д.Энхболд -Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: М.Болдбаатар -Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч, хурандаа

Т.Баяртогтох -Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал

Б.Нямдорж -Ховд Их сургуулийн захирал

Д.Баярмаа -Хөгжил политехник коллежийн захирал

Б.Мөнгөнцоож -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер хошууч

Нарийн бичгийн дарга:

Б.Ганхуяг -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, дэд хурандаа

3. “Оюутан цэрэг” сургалтын цэргийн ерөнхий бэлтгэл, мэргэжлийн бэлтгэл шатны сургалтуудыг зохион байгуулах бэлтгэлийг Ховд их сургууль / Б.Нямдорж /, Хөгжил политехник коллеж / Д.Баярмаа /-тэй хамтран хангахыг Цэргийн штаб /дэд хурандаа Б.Ганхуяг/, Зэвсэгт хүчний 123 дугаар анги /хурандаа М.Болдбаатар/ нарт тус тус даалгасугай.

4. Сургалтад хамрагдах оюутан суралцагчийг бүртгэх, элсүүлэх, сонгон шалгаруулалт явуулахыг Цэргийн штабын дарга /дэд хурандаа Б.Ганхуяг/-д, эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах ажлыг 2019 оны 03 дугаар сард зохион байгуулахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв / Т.Баяртогтох /-д тус тус үүрэг болгосугай.

5. “Оюутан цэрэг” сургалтад шаардлагатай зардлыг Засгийн газрын 2017 оны 32 тогтоолоор батлагдсан “Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох журмын дагуу оюутан, суралцагчдаас 2 багц цагийн төлбөр хураан авч зарцуулахыг Цэргийн штабын дарга /дэд хурандаа Б.Ганхуяг/-д зөвшөөрсүгэй.

6. “Оюутан цэрэг” сургалтад шаардлагатай авто машин гарган ажиллуулах, “Оюутан цэрэг” сургалт зохион байгуулсан дүнг илтгэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ